

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: **2020-02-05**

Тендер шалгаруулалтын нэр: **Аймгийн төвийн 5, 9, 12, 13-р байрнуудын гадна тохижилт, тоглоомын талбайн ажил**

Тендер шалгаруулалтын дугаар: [ДУГАОНӨГ/202001009](#)

Дундговь аймгийн Засаг даргын тамгын газар, Орон нутгийн өмчийн газар нь эрх бүхий тендерт оролцогчдоос **“Аймгийн төвийн 5, 9, 12, 13-р байрнуудын гадна тохижилт, тоглоомын талбайн ажил”-ыг** гүйцэтгэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул (www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүй татаж авна уу. Мөн цахим тендер шалгаруулалтыг Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан "Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам"-ын дагуу зохион байгуулж байна.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50.000 (тавин мянган) төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байна. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: 2018, 2019 оны борлуулалтын орлогын дундаж нь батлагдсан төсөвт өртөгийн 30 хувиас багагүй байна.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Батлагдсан төсөвт өртгийн 30 хувиас багагүй байна

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: **Сүүлийн 2 жил 2018, 2019**

Сүүлийн 2 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлыг гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл / гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар, хүлээн авсан тухай акт / ирүүлэх жилийн тоо: **Сүүлийн 2 жил 2018, 2019**

Уг ажлыг гүйцэтгэхэд эрх бүхий байгууллагаас олгосон хүчин төгөлдөр доорх тусгай зөвшөөрөл шаардлагатай: **Шаардлагатай**

Тендерийн хамт 2,648,000 төгрөгийн дүнтэй цахим тендерийн баталгааг цахим баталгаа гаргах эрх бүхий арилжааны банкаар цахим тендерийн баталгаа гаргуулна.

Тендерийг 2020 оны 03-р сарын 09-ний өдрийн 11 цаг 00 минутаас өмнө цахим системээр (www.tender.gov.mn) хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2020 оны 03-р сарын 09-ний өдрийн 11 цаг 30 минутад нээнэ.

Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй.
Давуу эрхийн зөрүү тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээс авч болно.

Дундговь аймгийн
Орон нутгийн өмчийн газар 70593399